

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
10 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэж, 5 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр уламжлав.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 22 өргөдөл бичгээр хүлээн авч, 15 өргөдлийг шийдвэрлэж, 7 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж, аймгийн Засаг даргын Тамгын газарт 6 өргөдөл бичгээр хүлээн авч, 5 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа мөн хүлээгдэж, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 6 өргөдөл хүлээн авч 5 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 45 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 43, биечлэн 2 иргэн санал, гомдол ирүүлснээс гомдол 17, санал хүсэлт 26, шүүмжлэл 2 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 40 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэсэн ба шийдвэрлэлт 89.9 хувьтай байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг “Саналын хайрцгаар өргөдөл хүлээн авах журам”-ын дагуу тайлант сард санал хүсэлтийн хайрцагт ирсэн өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 18 санал хүсэлт хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж санал хүсэлтийн хариуг бүрэн илгээж, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 10 дугаар сарын санхүүжилтийг олгож, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хугацаанд нь санхүүжүүллээ.

Орон нутгийн төсвийн 3 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэлээр орлогод 6668,3 сая төгрөг орж төлөвлөгөө 493,6 сая төгрөгөөр буюу 6,9 хувиар тасарсан байна. Үүнээс татварын орлогоор 5302,6 сая төгрөг орж төлөвлөгөө 306,0 сая төгрөгөөр буюу 5,5 хувиар, хөрөнгийн орлого 38 хувиар, татварын бус орлогоор 503,4 сая төгрөг оруулж төлөвлөгөө 57,0 сая төгрөгөөр буюу 11,2 хувиар тус тус тасарсан байна.

Дээд шатны төсвөөс авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 136,2 сая төгрөгөөр дутуу ирсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 41698,6 сая төгрөгт хүрч төсөвлөснөөс 3491,0 сая төгрөгөөр, үүнээс орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал зарлага 13673,1 сая төгрөгт хүрч, 2632,4 сая төгрөгөөр, орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын зарлага 27929,8 сая төгрөгт хүрч 1273,6 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зарлага 1459,3 сая төгрөгт хүрч, төсөвлөснөөс 401,0 сая төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн зарлага 528,9 сая төгрөгт хүрч 1095,3 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй гарсан урьдчилсан дүн мэдээтэй байна.

Орон нутгийн төсвийн өр 506,7 сая, авлага 538,2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 505,0 сая төгрөгөөр буурч авлага 67,0 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ улирлын байдлаар улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 1559,1 сая төгрөг оруулахаас 1371,3 сая төгрөг оруулж төлөвлөгөө 187,8 сая төгрөгөөр буюу 12,1 хувиар тасарсан байна.

Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагуудын өөрийн орлогод 128,4 сая төгрөг орж төлөвлөгөө 88,9 хувийн биелэлттэй байна.

Эрүүл мэнд, спортын салбарын төсвийн зарлага 3217,7 сая төгрөг гарсан нь төлөвлөснөөс 0,2 сая төгрөгөөр дутуу гарч, өр 88,2 сая, авлага 9,3 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 24,2 сая төгрөгөөр, авлага 8,1 сая төгрөгөөр өссөн байна. Өрийг оны эхтэй харьцуулахад 43,3 сая төгрөгөөр өссөн байна.

Боловсрол, соёл, урлаг, спортын салбарын төсвийн зарлага 24330,6 сая төгрөг гарсан нь төлөвлөснөөс 1262,6 сая төгрөгөөр дутуу гарч, өр 213,2 сая, авлага 27,7 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс өр 419,6 сая төгрөгөөр өсөж, авлага 9,7 сая төгрөгөөр буурсан байна. Өрийг оны эхтэй харьцуулахад 126,4 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт өрийг эдийн засгийн ангиллаар задлахад ажиллах хүчинтэй холбогдсон зардал 206,3, тогтмол зардал 91.7, хоол 57.7, шатахууны 39.5, томилолт 8.5, урсгал засвар 42.7, тэтгэмж 3,6 сая төгрөгийн өр ихэнх хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 185,1 сая, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 1235,5 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 339,8 сая, нийт 1760,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс орон нутгийн хөрөнгө оруулалт 168,4 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 164,9 сая, ОНХС-аас 766,9 сая, нийт 1100,2 сая төгрөг олгож зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй эрх нь шилжиж ирсэн санхүүжилтийг ажлын гүйцэтгэл, баримтын бүрдлийг шалгаж Эрүүл мэндийн сайдын эрх шилжсэн 1572,9 сая, Боловсрол соёлын 821,9 сая, нийт 2394,8 сая төгрөг олгосныг Сангийн сайдын 2017 оны 415 дугаар тушаалын 6 дугаар хавсралт маягтын дагуу Засаг даргаар батлуулан холбогдох яамд болон Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилт, системийн бүртгэл хангалтгүй байгаа тул “Тогтвортой амьжиргаа-3” төсөлтэй хамтран аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн 25 хүнд 1 өдрийн сургалтыг 10 дугаар 05-ны өдөр зохион байгуулж, өнгөрсөн жилүүдэд гарч байсан зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг чиглэл өглөө.

Нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд “Санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх” сургалтыг улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүч, нягтлан бодогч 130 гаруй хүнд Сангийн яамны 2 сургагч багшийн удирдлаган дор 10 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулав.

Аймгийн нягтлан бодогч нарын мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авах зорилгоор нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын 14 хоногийн сургалтыг хийв.

Төсөвт байгууллагуудын нярав албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, эд хариуцагчийн эрх олгох 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, 30 гаруй алба хаагчид хамрагдаж, эд хариуцагчийн эрх олголоо.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн “Тунгалаг бүртгэл” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 8 сумын санхүүгийн алба болон төсөвт байгууллагууд, аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаатай танилцаж, үр дүнд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, санхүүгийн холбогдолтой

хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Төсвийн 40 албан байгууллагаас 560.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийн хүсэлт ирснийг Сангийн яамны төрийн сангийн газарт илгээж санхүүжилтын эрхийг нээлгэж гүйлгээг тухай бүр хийлээ.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Төрийн сангийн газраас аймгийн 2016, 2017 оны санхүү, төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын зөвлөмж, албан шаардлага, актыг барагдуулахаар ажлын төлөвлөгөөний төсөл бэлтгэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 77 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу аймгийн хэмжээний төсвийн өр, авлагыг барагдуулах ажлын хэсгийг байгуулж, өр, авлагыг барагдуулж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, 2017 оны үйл ажиллагааны болон хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 30 байгууллагад шалгалт хийхээр төлөвлөсөнөөс 25 байгууллагад төлөвлөгөөт шалгалтыг, 3 байгууллагад гомдол хүсэлтээр хяналт шалгалтыг хийж 121,6 сая төгрөгийн акт тавигдсан.

Тайлант сард Булган сумын боловсрол, соёлын байгууллагын 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгахад 13,6 сая, Жаргалант сумын 1, 13 дугаар цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгахад 3,2 сая төгрөгийн акт, 8.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж албан шаардлага хүргүүлээд байна.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс 1 удаа хуралдаж, 5 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 2 иргэний анхан шатны бичиг баримт боловсруулж тусламж үйлчилгээ үзүүлэв.

Архивын тасаг нь 25 иргэнд лавлагаа, магадлагаа олгож, 2 хөмрөгийн 1968-1990 оны 30 ширхэг хадгаламжийн нэгж буюу 3586 хуудсыг данс, бүртгэлийн хамт цахим хэлбэрт шилжүүллээ.

Цагдаагийн газар: Иргэд олон нийтэд хууль эрх зүйг сурталчлан таниулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Илрүүлэлт-оргодол” нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 15 байгууллага, аж ахуйн нэгжийн 471 иргэнд Зөрчлийн тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай

хуулиудаар сургалт зохион байгуулж, иргэдийн хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэв. Тус сургалтаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 5 төрлийн 250 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, тараав. Мөн 181 аж ахуйн нэгж байгууллагад хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийлээ.

“Тайван-Амгалан-Ховдчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хуулиа хэрэгжүүлж, үүргээ биелүүлье” дэвжээ тэмцээн, “Архины хор” илтгэлийн уралдааныг ерөнхий боловсролын дунд сургуулийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулав.

Ховд Их Сургууль, Хөгжил Политехник коллежийн “Оюутны холбоод”-той ажиллах хамтын гэрээ байгуулсан ба ахлах ангийн 900 сурагчдад “Мэргэжлийн сонгох чиг баримжаа”, “Архигүй, аюулгүй нийгэм” сургалтыг зохион байгуулсны зэрэгцээ Жаргалант сумын хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдний үзэл бодол сэтгэл зүйд нийцсэн ажил арга хэмжээ зохион байгуулах, аливаа эрсдэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд багачуудын дуу хоолой болох “Хүүхдийн элч”-ийг сонгож батламжлав.

Аймгийн хэмжээнд 10 дугаар сарын 25-ны байдлаар 35 гэмт хэрэг бүртгэгдсэн. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: хулгайлах 13, үүнээс малын хулгай 5, иргэдийн өмчийн хулгай 8, хүчиндэх 1, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 6, бусдыг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх 2, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5, хууль бусаар мод бэлтгэх 2, хуурамч бичиг баримт үйлдэх гэмт хэрэг 1 тус тус бүртгэгдэж, хуулийн хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байна.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 337 гомдол мэдээлэл хүлээн авсны гэмт хэрэг 51 буюу 15.1 хувийг, 286 буюу 84.8 хувийг захиргааны зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байгаа бөгөөд зөрчил гаргасан 132 хүнийг албадан саатуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, жижгээр танхайрсан 24 иргэнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, 54 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, зөрчил гаргасан 789 хүнийг 37.265.000 мянган төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар—457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Тус газар нь нийт 64 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар, дэд бөгөөд гүйцэтгэх

ажил, харуул хамгаалалт хариуцсан дарга 1, ахлах нийгмийн ажилтан 1, ерөнхий жижүүр 1 нийт 3 албан хаагч томилогдоогүй 61 алба хаагчтай ажиллаж байна. Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр өндөр насны тэтгэвэрт гарсан 6 алба хаагчдад тус тус 1 тн нүүрс үнэгүй олгов.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны “Тангараг өргүүлэх тухай” А/206 дугаар тушаалын дагуу нийт бие бүрэлдэхүүн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн тангараг”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг” өргөх ёслолын ажиллагааг ангийн байрлалд зохион байгууллаа.

Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, цэрэгжилт, жагсаалч байдлыг хангах, ажлын цаг ашиглалт, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор ажил эхлэх, дуусах цагуудад нэгтгэн жагсааж бүртгэн, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж 7 хоногийн Баасан гараг бүр нийт бүрэлдэхүүнд хичээл, сургалт, мэдээлэл хийж, жагсаалын бэлтгэл, хувцасны үзлэгт хамруулан, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулав.

Тус газрын шинээр баригдаж буй Цагдан хорих байр болон конторын барилгын ажилд бусдад төлөх өр төлбөртэй нэр бүхий 13 хоригдлыг туслах ажилтнаар ажиллуулах гэрээ байгуулан ажиллуулав. Барилгын ажил дуусаж улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

Өвөлжитийн бэлтгэл ажил хангах, хадлан тэжээл бэлтгэх, ургац хураалтын ажлыг дуусгах тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын өгсөн үүрэг чиглэлийг бүрэн биелүүлэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газартай хамтран ажиллах гэрээнд тусгагдсан хуваарьт өдрүүдэд тус албанаас 5 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Хорих ангийн харуул хамгаалалтыг “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд ангийн даргын тушаалаар онцгой учралын үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн шуурхай бүлгийн алба хаагчдыг гарч болзошгүй гэмт хэрэг, учирлаас урьдчилан сэргийлэх, болзошгүй ажиллагааны үед ашиглагдах Тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад тухай бүр үүрэг даалгавар өгч биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд хоригдол, хоригдогч нараас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Шүүхийн шинжилгээний алба: Тус албанд 23 албан бичиг, 64 шинжилгээний тогтоол, захирамж ирснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 18 албан бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 2 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 27 хүнд, химийн шинжилгээ 14, биологийн шинжилгээ 9, криминалистикийн шинжилгээ 6 тус тус хийж, нийт 58 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд криминалистикийн шинжээч, шинжээч эмч, туслах ажилтан нар 2 удаа явж үүрэгт ажлаа гүйцэтгэв. Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 51 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 16 ширхэг мөр, гутлын 14 мөр, тээврийн хэрэгслийн мөр 30, бусад ул мөр, эд мөрийн баримт 37 илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 61 тус тус авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийв.

Криминалистикийн шинжээч нар гэрэл зургийн ажил 499 хийснээс шинжилгээний 24, хэргийн газрын үзлэгийн 337, цогцосны үзлэг задлан шинжилгээний 63, бусад 73 тус тус хийж, цагдаагийн байгууллагад хүргүүлэв. Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн, хими, биологийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүдийг тухай бүрт нь цахимжуулан ажиллав.

Алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй, улсын төсвөөс нийт 187,519,000 төгрөгийн төсөв батлагдсанаас 2017 оны эхний 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 144.872.451 төгрөг зарцуулсан. Төлбөрт үйлчилгээний орлогод 4,103,000 төгрөг төвлөрүүлээд байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Тайлант сард 2820 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 2084, аймгийн хэмжээнд нийт шилжих хөдөлгөөнд хамрагдсан иргэд 631 ба шилжин ирсэн иргэд 81, шилжин явсан иргэд 84 иргэн, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 466, гадаад паспорт олголт болон сунгалт 340, иргэний үнэмлэх шинээр олгосон 99, сунгалт 187, дахин олгосон

86, иргэний бүртгэлийн лавлагаа 418 иргэнд тус тус олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 323 бүртгэл хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 684, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 128 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж ажиллав.

Иргэдээс 11 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс 7 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хугацаа болоогүй 4 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа байна.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсрол, соёл, спортын чиглэлээр: Улсын чанартай олимпиад, уралдаан, тэмцээнд өөрөө болон шавь нар нь амжилт үзүүлсэн 11 багш, 2017 оны элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэсэн шавь нь амжилт үзүүлж аймагт тэргүүлсэн 21 багш нийт 32 багшид 4,700 000 төгрөгийн мөнгөн урамшууллыг “Чадварлаг багш” дэд хөтөлбөрийн санхүүжилтийн хүрээнд олгов.

“Багшийн ёс зүйг эрхэмлэх боломж” эсээ бичлэгийн уралдааныг сургууль, цэцэрлэгийн 1-5 жил ажиллаж буй багш нарыг хамруулан, сурагчдын дунд “Багш дор мөргөмүй” зохион бичлэгийн уралдааныг 2 үе шаттай, “Би хүүхдийн хүндлэл хүлээсэн багш” эсээ бичлэгийн уралдаан тус тус зохион байгуулж, ахмад 123 багшид “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан хүндэтгэл үзүүллээ.

Глобаль сангийн ДОХ-ын төслийн дэмжлэгээр “Өсвөр үе, залуучуудад ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх боловсрол олгох “Үе тэнгийн сургагч”-дыг бэлтгэн чадваржуулах хөтөлбөрийг ЕБС-ийн сурагчдад олгох зорилгоор Жаргалант сумын 7 сургуулийн 28 сурагч, ХоИС-ийн 2, Хөгжил политехник коллежийн 2 оюутан, 10 багш нийт 42 хүнийг хамруулан сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.

“Бид хамтдаа өөрчилж чадна” сэдэвт олон улсын эко сургууль хөтөлбөрийн үндэсний 3 дугаар чуулган БОАЖЯам, Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар, БСШУСЯам Swiss Cooperation in Mongolia ESD Project, Тогтвортой Хөгжлийн Боловсрол төсөл, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, нийслэлийн Боловсролын газар, Байгаль орчны газруудтай хамтран зохион байгууллаа.

Боловсролын үнэлгээний төвөөс “Үр дүнд суурилсан даалгавар боловсруулах арга зүй” сургалтад байгалийн ухааны, математикийн багш болон сургалтын менежер нийт 75 хүн, цэцэрлэгүүдийн арга зүйч, бүлгийн багш 80 албан хаагчдад хүүхдийн үнэлгээ, сургалтын арга зүйн чиглэлээр, түүнчлэн Монгол хэл бичиг, ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх хүрээнд бага ангийн багш, сургалтын менежер, МХУЗ-ын багш нарын

хамтын оролцоонд түшиглэн “Монгол хэл бичгийн сургалтын чанарыг дээшлүүлэх” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

2014-2017 онуудад ЕБС-ийн бага ангид өгсөн сурах бичгийн судалгаа гаргаж элэгдэл, хорогдлыг тооцож, дутагдалтай сурах бичгийн судалгаа гарган, YI-XI ангийн сурагчдын 49 төрлийн сурах бичиг, 10 дугаар ангийн бизнес судлалын багшийн ном, дотуур байрны багшийн дэвтэр, STEM сургалтын CD-г сургуулиудад хүлээлгэн өгөв.

Аймгийн Хөгжимт драмын театр, Музей, Нийтийн номын сан болон сумдын Соёлын төвүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлүүлэх талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв.

Төрийн шагналт Ардын Жүжигчин Ж.Чулууны нэрэмжит “Алтан гадас одонт” Хөгжимт Драмын Театр нь 2017 оны өвөл цагийн уран бүтээлийн 80 дахь жилийн нээлтийн үйл ажиллагааг тохиолдуулан ахмад уран бүтээлчидтэй хамтран 8 уран бүтээлийг сэргээн туурвих ажлыг зохион байгуулахаар ажлын хэсэг томилогдон бэлтгэл ажлууд хийгдэж ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна.

Биеийн тамир спортын сургалт, бэлтгэлийн хуваарийн дагуу спортын 10 төрлөөр 550 гаруй тамирчин сурагчид өвөл цагийн бэлтгэл сургуулилтанд хамрагдаж, бус, улсын чанартай тэмцээнүүдэд бэлтгэгдэж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах тусламж, үйлчилгээний зайлшгүй шаардлагатай багцыг эрүүл мэндийн анхан шатанд нэвтрүүлэх талаар эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг сайжруулах зорилгоор “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх орон нутгийн чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт бүсийн сургалтыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр амжилттай зохион байгууллаа.

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Томуугийн эсрэг дархлаажуулалт” уриан дор зохион байгуулж, томуугийн эсрэг вакцин 2400 хүн тун, улаанбурханы эсрэг вакцин 590 хүн тун, нийт 213,8 сая төгрөгний вакциныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанаас захиалан авч сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдрүү хуваарилан хүргүүлснээр томуугийн вакцин 50%, улаанбурхан, сахуу, татрангийн эсрэг дархлаажуулалтын хамралт 45%тай тус тус хийгдэж байна.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 5012 хүн амбулаториор үйлчлүүлсний 212 нь томуу, томуу төст гэж оношлогдон үүнээс 16 нь уушигны хатгаагаар хүндрэн

эмнэлэгт хэвтэн жмчлүүлж, түргэн тусламжийн 187 дуудлагаас иргэдэд үйлчлэв. Амбулаторит эзлэх томуу 4.2 хувь бүртэгдсэн нь өмнөх 7хоногоос 0,2 хувиар их, өмнөх оны мөн үеэс 1,0 хувиар их байна.

“Антибиотикийг хариуцлагатай хэрэглэе” өдөрлөгт арга хэмжээний хүрээнд худалдаа үйлчилгээ эрхэлдэг болон түүгээр үйлчлүүлж буй иргэдэд эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөөний талаарх мэдээлэл, сурталчилгааг хийж, 820 гаруй тараах материал тараан, зөвлөмж хүргэж ажиллав.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр: Тайлант сард нийт 253 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 525 иргэний мэдээллийг шинэчлэн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүлсэн. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй 1944 ажилгүй иргэд үүнээс эмэгтэй 1031 байна. Шинээр бий болсон 529 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн LMIS санд оруулав.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллага иргэдээс 1294 ажлын байрны захиалга авч бүртгэлтэй ажил хайгч иргэдээс 1207, үүнээс эмэгтэй 612 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Байнгын 746, улирлын 161, түр 300 ажлын байранд зуучлав. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх үйлчилгээнд нийт 632 иргэд, үүнээс бүлгийн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 489, ганцаарчилсан зөвлөгөөнд 143 иргэн хамрууллаа.

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр байгуулж уг төвийн нээлтийн арга хэмжээнд 120 гаруй ажил хайгч залуучууд оролцлоо. Энэхүү төвд хөдөлмөрийн зах зээлд хөл тавьж буй шинэхэн сургууль төгссөн, ажлын туршлагагүй залуучуудыг идэвхижүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн шинэ үйлчилгээ, арга хэрэгслийг нэвтрүүлэх юм. Тухайлбал, ажил хайж буй залуу хүний хөдөлмөр эрхлэх чадварыг нь үнэлж, улмаар тухайн хүний онцлогт тохируулан хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг боловсруулах ба Залуучууд хоорондын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор бүлгийн модуль сургалтыг 4 долоо хоногийн хугацаатай зохион байгуулах бөгөөд энэ явцад ажил хайгч залуу өөрийгөө илүү танин мэдэх, ажил олгогчтой холбоо тогтоох, ярилцлагад амжилттай орох ур чадвар, чадамжаа хөгжүүлэх боломжтой болж, ажил хайх, олохтой холбоотой өөрийн туршлага, сургамжаас бүлгийн бусад гишүүддээ

хуваалцах боломж бүрдэж, 15-34 насны залуучуудыг хамруулан ганцаарчилсан болон бүлгээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа явуулах юм.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох түр сургалтыг 35 иргэнд тогооч, 15 иргэнд оёдолчин мэргэжлээр “Сайн хүн” төрийн бус байгууллагатай хамтран амжилттай зохион байгууллаа. Тогооч мэргэжлээр 50 нэр төрлийн хоол үйлдвэрлэх чадамжийг эзэмшүүлж мэргэжлийн үнэмлэх чадамжийн гэрчилгээг, үсчин мэргэжлээр 30 ажилгүй иргэнд анхан шатны мэргэжил олгох тус тус сургалтыг зохион байгуулж 6 иргэнийг байнгын ажлын байранд зуучлав.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг иргэдэд шуурхай хүргэж, улсын төсвөөс нийт 1.812.900.000 төгрөгийн санхүүжилт авч, алдарт эхийн одонд 1.2 тэрбум, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 89.0 сая, ахмадын “Насны хишиг”-т 506.0 сая төгрөг тус тус зарцуулж, орон нутгийн төсвөөс 5.2 тэрбум төгрөгийн санхүүжилт авснаас 435.0 сая төгрөгийн дутуу олголттой байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2017 оны А/08 тоот тушаалаар баталсан Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг 2017 оны 3 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 09-ныг дуусталх хугацаанд аймгийн хэмжээнд мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж 16055 өрхөд хүрч ажилласан ба энэхүү бүрдүүлсэн өрхийн мэдээлэлд үндэслэн тэдгээрийн амьжиргааны түвшинг тодорхойлох буюу өрх тус бүрийн оноог бодож, амьжиргааны түвшнээр эрэмбэлэн мэдээллийн сангийн чанар, үнэн бодит байдлыг бий болгох зорилгоор амьжиргааны түвшинг тодорхойлоход нөлөөтэй байгаа зарим үзүүлэлтийг бусад сангуудтай тулган шалгахад эх сурвалжаас илтэд зөрүүтэй байгаа байдал ихээр гарч байгаа учир албан эх сурвалжаас зөрүүтэй байгаа өрхийн зарим үзүүлэлтийг тухайн өрхийн тэргүүн болон насанд хүрсэн гишүүнтэй ярилцан тодруулах замаар мэдээллийн зөрүүг засварлан Өрхийн мэдээллийн нэгдсэн санд зааврын дагуу оруулж судалгаанд хамрагдсан өрхүүдийн оноог эцэслэн бодох боломжийг бүрдүүлэх зорилгоор баталгаажуулалтын ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 25-аас 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан ба аймгийн хэмжээнд 9665 өрхийн мэдээлэл зөрүүтэй байснаас 8030 өрхтэй холбогдож мэдээллийг нь баталгаажуулав. Аймгийн хэмжээнд баталгаажуулалтын ажил 83 хувьтай байга ба малчин өрхүүд зун гантай болсонтой холбоотойгоор отор нүүдэл

ихээр хийж байгаа учир холбогдож мэдээллийг нь баталгаажуулахад бэрхшээлтэй байсан тул Жаргалант сумын 12 багийн нийгмийн ажилтантай хамтран мэдээлэл нь зөрүүтэй өрхүүдтэй холбогдож ажилласан боловч иргэдийн идэвхи оролцоо муу байгаагаас баталгаажуулалтын ажил удааширч 54 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант сард хүнсний эрхийн бичгийн цаасан болон цахим хэлбэрээр үйлчилгээ авдаг 803 өрхөд /том хүн 2710, хүүхэд 2331/ 50381000 төгрөгийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээгдэж байна.

2017 оны судалгаанд хамрагдаагүй, өрхийн амьжиргааны түвшингээ тодорхойлуулж хүүхдийн мөнгөнд хамрагдах хүсэлтэй 27 өрхийн өргөдөл хүсэлтийг хүлээн авав. Шинээр төрсөн болон ӨМНС-д бүртгэлгүй байсан 38 хүүхдийн мэдээллийг мөн бүртгэв.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд магадлан итгэмжлэгдсэн Мөнхцохилохуй, Ачлалт наран хайрхан, Элбэрэлт бүжинлхам, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхийн холбооны Итгэл төв, Очир сүлд 4 байгууллагатай журмын дагуу хамтран ажиллах гэрээ байгуулж, сэргээн засах өдрийн үйлчилгээнд 32 ахмад настанг хамруулав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс хуралдаж 14 зорилтот бүлгийн хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын тохирох үйлчилгээнд хамрууллаа. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд халамжийн сангаас Ортопедийн тусгай хэрэгсэл авсан эсэхийг программд шалгаж, үйлчилгээ авах эрх үүссэн 36 иргэний бичиг баримтыг хүлээн авч ортопедийн туслах хэрэгсэл олгохын зэрэгцээ wais программд бүртгэж баталгаажуулав.

“Цагаан уул” ахмадын амралт сувиллын цогцолборт 31 ахмад амарч 282 ор хоногийн 1,8 сая төгрөгийн ахмадаас, халамжийн сангаас 3,7 сая төгрөг нийт 4,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн 20 асруулагчдад стандартын дагуу өдөрт 4 удаа 15 нэр төрлийн хоол хүнсийг илчлэгийг нь тооцон үйлчилж, асруулагчдыг халуун усанд оруулж, хэвтрийн асруулагчдад өдөр бүр тогтмол мэргэжлийн асаргаа үйлчилгээ үзүүлж, 2017 оны 10 сард асруулагчдын хоол хүнс, эмэнд 2, 6 сая төгрөг зарцууллаа. Эрүүл мэндийн даатгуулагчийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилогоо шинжилгээнд хамруулах, оношлох лабораторыг сонгон

шалгаруулж, тэнцсэн БОЭТөв, Ач заяа, Мөнхцохилохуй эмнэлэгүүдтэй гэрээ байгуулан орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагаар сурталчлан, 40, 45,50,55,60,65 насны даатгуулагчдад урилгаар зар хүргэж, 40-65 насны даатгуулагчдыг элэгний В,С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулахаар мэдээллийг түгээж, БОЭТөв эмнэлэгтэй нэмэлтээр гэрээлэн оношлуурын нөөц бүрдүүлэх шаардлагаар урьдчилгаа санхүүжилтийг олгоод байна.

Сайн дурын даатгалд 5383 даатгуулагчийн 845,2 сая төгрөг, 10486 даатгуулагчийн 452,8 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын орлого, 739 ажил олгогч 13203 даатгуулагч хамрагдаж, шимтгэлийн орлого 9,954 сая төгрөг төвлөрүүлээд байна.

Тайлант хугацаанд өндөр насны тэтгэвэрт 7530 хүнд 12562591,1 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1743 хүнд 2103912.2 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 824 хүнд 1065685.2 мянган төгрөг, цэргийн тэтгэвэрт 214 хүнд 614700.7 мянган төгрөг, үйлдвэрийн ослын тэтгэвэрт 38 хүнд 70992,9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 1065 даатгуулагчид 1122537.2 сая төгрөг, ХЧТА-н тэтгэмжид 655 даатгуулагчид 68265.1 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 1489 даатгуулагчид 337090.5 сая төгрөг, 280 даатгуулагчийн оршуулгын тэтгэмжид 280,000,000 төгрөгийг тус тус олгов.

ЭХМКомиссын ээлжит хурлыг 10 дугаар сард 4 удаа зохион байгуулж, нийт 240 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааны асуудлыг хэлэлцэж 185 иргэний актыг сунгаж, 20 иргэний актыг цуцалж, 33 иргэний хугацааны актыг шинээр тогтоож, 10 дугаар сарын байдлаар мэдээллийн баазад 3294 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, оролцооны чиглэлээр: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож баривчлах арга хэмжээ авч Цагдаагийн газарт саатуулагдсан 16 иргэнд 2 удаагийн сургалт, зөвлөгөө өгсөн ба оролцогчдоос эцэг эх, хүүхдийн харилцаа, үүрэг хариуцлагатай холбоотой асуудлаар судалгаа авч нэгтгэн архи ууж, гэр бүлдээ амар тайван байх нөхцлийг бүрдүүлэхгүй бусдын эрхэнд халдах, орчиндоо түгшүүр төрүүлэх болсон шалтгааныг тодруулж гэр бүлтэй нь цогцоор нь ажиллах, хамтарсан багийн гишүүдэд холбон зуучилж сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зан үйлийг нь засах, багийн нийгмийн ажилтнуудад эргэх холбоо үүсгэх арга хэмжээ авав.

Угийн бичиг хөтлөх талаар иргэдэд ойлголт мэдлэг өгч, Монгол хүний удмын санг цэвэр ариунаар авч үлдэх чухал санаачлагыг өрнүүлж айл өрх бүрийг хамруулан хүүхэд багачууд, залуучуудад сурталчилж ажиллах, цус ойртолтын тухай ойлголтыг хүмүүст хүргэх сургалтын удирдамж, хөтөлбөр боловсруулаад байна.

Шинээр хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах, сумын Хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлөх зорилготой орон нутаг дахь хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчдийн чадавхи бэхжүүлэх сургалтыг баруун болон төвийн бүсийн сумдад зохион байгуулж төрийн албан хаагч, эцэг эх, олон нийтийн төлөөлөл болох 600 гаруй хүнийг хамрууллаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн болон биеэр ирж мэдээлсэн хоёр кейсийг судлан нөхцөл байдлын үнэлгээ болон үйл явцын тэмдэглэл хөтөлж зохих байгууллагад холбон зуучлалаар ажиллаж байна.

“Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Хөгжил Политехник коллежийн охид хөвгүүдэд “Өсвөр үеийнхний өмнө тулгамдаж буй асуудал” болон “Биеэ авч явах соёл” сэдвээр мэдээлэл хийж 200 оюутанд мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ажилчдад “Эрүүл харилцаа Эерэг хандлага”, “Охин үрээ хайрла” сэдэвт нөлөөллийн сургалтыг тус тус зохион байгуулж, сургалтын явцад өсвөр насны охинтойгоо харилцах харилцаа, эерэг хандлагын талаарх мэдээлэл өгч харилцан санал бодлоо солилцов.

Тав: Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:

Байгаль орчны чиглэлээр: Монгол Улсын Их Сургууль, ТНС байгууллага, Ховд их сургууль хамтран газарзүйн мэдээллийн системийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, уул уурхайн төслийн нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг тодорхойлох, дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх газар нутгийг сонгох, талбайн хэмжээг тодорхойлох арга, аргачлалыг эзэмшүүлэх зорилгоор “Газарзүйн мэдээллийн систем, дүйцүүлэн хамгааллын тооцооллын программ” сэдэвт 36 цагийн сургалтыг Ховд, Увс, Завхан, Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 50 гаруй хүн хамрагдсан бөгөөд оролцогчдод сертификат олгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, “Тогтвортой бичил уурхай” төсөл хамтран 2017 онд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Яамдын сайдын тушаалаар батлагдсан бичил уурхайтай холбоотой хууль, журам, дүрэм, аргачлалыг орон нутгийн удирдлагууд, бичил уурхай эрхлэгчдэд танилцуулж нэгдсэн ойлголттой болох, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг бичил уурхайн зохион байгуулалтанд оруулж ашигт малтмалын хууль бус олборлолтыг таслан зогсооход хувь нэмэр оруулах зорилготой “Бичил уурхайн эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Баянхонгор аймагт, 10 дугаар сарын 27-ны өдөр Увс аймагт тус тус зохион байгууллаа. Сургалтын явцад бичил уурхайн эрхзүйн орчин төрөөс баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, орон нутагт оруулж буй хувь нэмрийн талаар мэдээлэл өглөө. Мөн бичил уурхайн чиглэлээр зохион байгуулалтанд орж ажиллаж буй Баянхонгор аймгийн “ХАМОДХ” нөхөрлөл, “Хонгорын хүдэр” ХХК-ний баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа.

2017 оны 10 дугаар сарын 13-ны өдөр байгаль орчны салбар байгууллагуудын нэгдсэн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, энэ үеэр модны тарьц, суулгацны үзэсгэлэн худалдааг гаргаж, иргэдийг үндэсний мод тарих өдрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг уриаллаа. “Нээлттэй хаалга”-ны өдрөөр Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сум дундын Ойн анги, “Үр жимс” хоршоо, “Ховд сафари” ХХК улиас, бургас, хайлаас, шар хуайс, агч, голт бор зэрэг гоёлын модны суулгацаар үзэсгэлэн гаргаж, Чандмань сум 70 ш, Мөнххайрхан сум 50ш, Дөргөн сум 50ш, иргэд 20 гаруй гоёлын мод худалдан авч, нийт 6 байгууллага, 3 аж ахуйн нэгжийн 100 гаруй албан хаагч ажилчид оролцож, 120 иргэдэд гарын авлага мэдээллээр хүрч үйлчиллээ.

Цоохор ирвэсийг хамгаалах олон улсын өдөр 10 дугаар сарын 23–ны өдөр тохиож уг өдрийг тохиолдуулан БОАЖГазар, МХГазар, Жаргалант сумтай хамтран “Иргэн бүр эрсдэлгүй орчинд” аяныг зохион байгуулж, олон нийтэд сурталчлах, томоохон зах худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэдтэй уулзаж, байгаль орчны талаарх хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, зөрчлийн тухай хуулийг сурталчлах, ирвэсийн талаар иргэдийн ойлголт, ойн тухай хууль гэх мэт байгаль орчны багц хуулийн ойлголтуудыг ард иргэд, оюутан залууст хүргэж ТВ нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээв. Байгаль орчин, аялал жуулчлал, Барилга хот байгуулалтын сайдын

хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангаж голын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг тогтоох ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 28-ний өдрийн захирамжийн дагуу 2017 оны 10 сарын 9-20-ны өдрүүдэд сумдад ажиллав. Сумдын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал, багуудын Засаг дарга нартай голын онцгой хамгаалалт, энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсэд орсон газруудын талаар ярилцаж зурагт тэмдэглэгээ хийж санал солилцов.

Мод тарих үндэсний өдрийг зарлах тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, Засгийн газарт чиглэл өгөх тухай 2013 оны 178 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мод тарих өдрөөр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт тавьж, тарих суулгацыг технологи, зааврын дагуу тарьж ургуулах, арчилан хамгаалахад зөвлөгөө өгч хамтран ажиллав. Намрын бүх нийтээр мод тарих аянаар 120 аж ахуйн нэгж, байгууллагын 3324 иргэн, орчин тойрон, бичил цэцэрлэг, саадуудад 10904 ширхэг мод, бут сөөг тариалж 16,309,900 төгрөгийн хөрөнгө зарцуулав. Аймгийн хэмжээнд хавар намрын мод тариалалтаар давхардсан тоогоор 303 аж ахуйн нэгж байгууллага, 9069 иргэн, 39016 мод, бут сөөгийг тариалсан байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/497 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2017 оны ойжуулалт, ногоон хэрмийн туслах зурвасын ажлыг шалгаж Дарви сумын Хөвхөрийн голд 2016, 2017 онд хийгдсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэл чанар, үр дүнтэй танилцахад “Үр жимс” хоршооны 2017 онд хийж гүйцэтгэсэн ойн зурвасын ажил 83,8, “Ховд сафари” ХХК-ны ойн зурвасын ажил 83,2, 2016 онд ойн зурвас байгуулсан ажлын 2 дахь жилийн арчилгаа хамгаалалтын сум дундын Ойн анги гүйцэтгэсэн талбайд 80 хувьтай, “Ховд сафари” ХХК-ны ажил 88,5 хувьтай, сум дундын Ойн ангийн Жаргалант сумын ногоон байгууламжийн ажил 75 хувийн гүйцэтгэлтэй байсан ба ажлын хэсэг акт тогтоон холбогдох материалуудыг ойн судалгаа хөгжлийн төвд хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Гурван Сэнхэр төвтэй таван од” аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн төслийг 2017 оны 10-р сарын 3-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн бариад байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2015 оны 82 дугаар тогтоол, 2017 оны 60 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх журам”

болон Тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд Булган, Алтай, Үенч, Мөст, Цэцэг, Дөргөн сумдад ажлын хэсэг ажилласан бөгөөд Бичил уурхай эрхлэгчид болон хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн судалгааг гаргах, цахим мэдээллийн сан үүсгэх, баяжуулалт хийж, нэгдсэн бүртгэлтэй болох, татвар, хөдөлмөр халамж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгч, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллав. Мөн Алтай сумын Бодонч багийн нутаг “Улаан богоч”, Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг “Цагаан эрэг”-т нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж буй компаниудын гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчлүүдийг арилгах чиглэл өгч, үйл ажиллагааг зогсоож лацдав.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу Жаргалант сумын Магсаржав багийн нутагт дэвсгэрт хэрэгжүүлж буй “Арслан бар” ХХК-ний “Өлөн гэдэс боловсруулах цэх”, Тахилт багийн нутагт байрлах “Хан жаргалант Ховд” ХХК-ний “Мах боловсруулах үйлдвэр”, Рашаант багийн нутагт байрлах “Хан Зэт Ойл” ХХК-ний хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Шатахуун түгээх станц” төслүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, зөвлөн тулах үйлчилгээг үзүүлэв.

Хавхг-Ховд аяны хүрээнд Мөст сумын байгаль хамгаалагч, байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагчтай хамтран хөдөөгийн 3 багт 3 удаа эргүүл хяналтаар явж, 70 гаруй айл өрх 120 гаруй ард иргэдтэй уулзаж тарвага агналт түүний хор уршиг, тахал өвчний талаар мэдээлэл өгч нийт 400 гаруй км зам туулж 41 хавх хураасан.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас санаачлан “Хавх булаагүй ууланд хамаг амьтан жаргалтай-3” аяныг удирдамжийн дагуу бүсийн хэмжээнд зохион байгуулж, аяны хаалтыг 2017 оны 10 сарын 12–нд Увс аймагт зохион байгуулж, уг үйл ажиллагаанд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл, Увс нийт 6 аймгийн 40 гаруй байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчид оролцсон бөгөөд 100 хавх цуглуулсан манай аймаг 3 дугаар байр эзэлж 3 ширхэг мотоциклоор шагнуулж ажлын үзүүлэлтээ ахиулав. Тус аяны хүрээнд Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгуудаас нийт 793 хавх хураагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/391 дүгээр захирамжаар “Цэвэрч Ховдчууд” 3 сарын болзолт уралдаан зарласан бөгөөд сар бүрийн “Пүрэв” гарагийг бүх нийтийн

цэвэрлэгээний өдөр болгон зарлаж энэхүү аяны хүрээнд нийт 7 удаагийн их цэвэрлэгээг зохион байгуулаад байна. Тус их цэвэрлэгээнд давхардсан тоогоор 95 албан байгууллагын 4535 албан хаагчид, 660 оюутан, 2420 сурагч, 3250 иргэн оролцож нийт 326 м³ буюу 109 машин хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэж устгав.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: 2017-2018 оны өвөл 91 багт 8435 малчин өрхийн 3663,5 мянган мал /үүнээс тэмээ 25,8 мянга, адуу 137,4 мянга, үхэр 201,3 мянга, хонь 1404,3 мянга, ямаа 1894,8 мянга/ хонин толгойд шилжүүлснээр 5408,0 мянган мал өвөлжих урьдчилсан дүн мэдээтэй байна.

Хилийн зурвас бүс нутагт 149 өрхийн 135,6 мянган мал, Улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 750 өрхийн 458,8 мянган мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт өвөлжих 329 өрхийн 262,4 мянган мал, өвөлжих төлөвтэй.

Аймгийн дүнгээр ашиглахад бэлэн 9401 хашаа байгаагаас бодын 1785 богийн 7616 хашаа байгаа ба хашааны хангамж 96 хувьтай байна.

Малын усан хангамжийн хувьд нийт 2085 худаг, уст цэг байгаагаас ашиглахад бэлэн 1942 буюу нийт худаг уст цэгийн 93,1 хувийг ашиглаж, усаар хангагдсан өрх 94,6 хувийг эзэлж байна.

Өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлыг хангах аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар албан даалгавар гарч тус албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 60,0 мянган тн хадлан, 4,0 мянган тн гар тэжээл, 5,7 мянган тн хужир шүү бэлтгэхээс хадлан 64,5 мянган тн, сүрэл 304 тн, ногоон тэжээл 143 тн, үйлдвэрийн тэжээл 358 тн, гар тэжээл 2,4 мянган тн, ногооны хаягдал 55 тн, хужир шүү 7,6 мянган тн-ыг тус тус бэлтгэгдээд байна.

Сумдын аюулгүй нөөцөд нийт 613,6 тн өвс, 140 тн тэжээл бэлтгэж, өвс 72,2 хувь, тэжээл 27,5 хувийн тус тус нөөц бэлтгэгдсэн байна. Аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөцөд нийт 200 тн өвс, 50 тн тэжээл бэлтгэгдсэн.

Малчин өрхүүд өвөлжилтийн хувийн бэлтгэлийг 90,7 хувиар, аймгийн мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл 77,4 хувиар хангагдсан. Аймгийн эдийн засаг хөгжлийн бодлогын асуудал хариуцсан Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг өвөлжилт хүндэрч болзошгүй Дөргөн, Чандмань, Дарви, Зэрэг сумдын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц гүйцэтгэлтэй танилцаж, бэлтгэл ажил хангалтгүй байгаа сумдын удирдлагуудад ажил эрчимжүүлэх үүрэг чиглэл өгөв.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан залуу малчдыг дэмжих “Залуу малчин” дэд хөтөлбөрийн төслийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн бариад байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан “Малчдад тусалъя” сайн санааны 3 сарын аян өрнүүлэхээр аймгийн Засаг даргын А/548 дугаар захирамжаар аян зохион байгуулах удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсон бөгөөд тус аяны нээлтийн арга хэмжээг 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Ард Аюушийн төв талбайд зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд үр тариа 214.6 га-гаас 224.5 тн, төмс 675.7 га-гаас 8860.9 тн, хүнсний ногоо 820.9 га-гаас 10205.3 тн, малын тэжээл 456.9 га-гаас 1735.1 тн, нийт 21025.8 тн ургац хураан аваад байна.

Авто замын чиглэлээр: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант суманд хэсэгчилсэн 3,8 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгч “Түм дэлгэрэх” ХХК төлөвлөсөн ажлын дагуу 2 км авто замын барилгын ажил, замын сангийн хөрөнгөөр Жаргалант сум доторх замын хөдөлгөөнд хүндрэлтэй байсан 33.2 км авто замд гарсан эвдрэл, хагаралыг нөхөх ажлыг хийж гүйцэтгэв.

“Ховд АЗЗА” ТӨХК нь төлөвлөгөөний дагуу Ховд Алтай чиглэлийн Ховдоос 26, 51, 76 дахь км-ийн авто зогсоолуудад бие засах газар, хогийн цэг байрлуулж, зам дагуух хог цэвэрлэж 1436 кг хогийг устгав. Мөн Манхан–Зэрэг чиглэлийн 100 км хатуу хучилттай авто зам дагуух 1234ш дохионы шонг сэргээн засварлан будаж, 38 ширхэг анхааруулах болон хориглох босоо тэмдгийг шинэчлэн, Ховд–Булган чиглэлийн авто зам дагуух унаж хугарсан туузан хашлагуудыг сэргээх, шинээр суулгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Барилга хот байгуулалтын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2017 оны А/416 дугаар захирамжаар томилогдсон улсын комиссын бүрэлдэхүүн Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт баригдсан “Турлиахт” ХХК-ийн 4 дүгээр ээлжийн 16 айлын орон сууцны барилга, “Тэгш таван өргөө” ХХК-ий 2 дугаар ээлжийн 16 айлын орон сууцны барилга угсралтын ажил, гүйцэтгэлийн явцтай танилцаж гүйцэтгэлийн ажлыг сайжруулж чанаржуулах үүрэг чиглэл өгөв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган суманд баригдсан 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил, Дарви сумын Ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургуулийн хичээлийн байрны засварын ажлууд зураг төсвийн дагуу хийгдэж, ажил

бүрэн дууссан тул улсын комиссын гишүүд барилгын ажлын гүйцэтгэлтэй танилцаж хүлээн авав.

Хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй "Хатантүнгэл" ХХК-ийн 12 айл, Шүүхийн шинжилгээний албан хаагчдын 20 айл, "Вива хотхон" ХХК-ийн 15 айл, "Гэрэл гэгээ наран" ХХК-ийн 24 айл, "Шинэ Асар" ХХК-ийн 16 айлын орон сууцны барилгын ажлын явц, гүйцэтгэлийн ажилд хяналт хийж холбогдох зөвлөмжийг өгч ажиллав.

Газар эзэмших зөвшөөрөл олгох 11, газар эзэмших эрх шилжүүлэх 10, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах 2, эзэмшил газрын хэмжээ талбай өөрчлөх 3 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлтийн явцыг холбогдох удирдлагуудад танилцуулан хуулийн хүрээнд гэрээ байгуулан, гэрчилгээ олгов. Мөн 28 иргэний газрын кадастрын зураг гаргаж, биржийн программд 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барьцаа болон үнийн мэдээг шивж баталгаажуулав.

Зургаа: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг 17 сумын Засаг даргын Тамгын газар, 91 багийн Засаг дарга, 90 төсөвт албан байгууллага, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 22 агентлаг бусад байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилт, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, эрх зүйн актуудын хэрэгжилт, үр дүн, орон нутгийн болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтыг газар дээр нь үзэж, танилцан заавар зөвлөгөө өгч, зөвлөн тусалж ажиллалаа.

Сум, байгууллагуудад ажилласан талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох зөвлөмжийг сум, байгууллагуудад хүргүүлэхээр болов.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 "Хөрөнгө шилжүүлэх тухай" 85, "Хөрөнгө бүртгэх тухай" 86, "Журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай" 87, "Хяналтын зөвлөлийн журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай" 88, "Агуулах бэлтгэх, түүнд хөрөнгө хадгалах журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай" 89, "Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслэх журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай" 90, "Түрээсийн гэрээний загвар баталж, төлбөрийн доод үнэ тогтоох тухай" 91, "Гэрээний загварын шинэчилсэн найруулга батлах тухай" 92, "Журам батлах тухай" 93, 95, "Журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай" 94, 101 дугаар тогтоолуудыг аймгийн удирдлагуудад танилцуулж, 2017 оны 10 дугаар сарын

23-ны өдрийн 2/2411 (1428 хуудас) дугаар албан бичгээр сумдад, 2/2410 (4970 хуудас) дугаар албан бичгээр албан байгууллагуудад тус тус хүргүүлэв.

2017 оны 10 дугаар сарын байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 3, Засгийн газрын 45 тогтоол, 14 хуралдааны тэмдэглэл, албан даалгавар 1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3, Тэргүүлэгчдийн 96 тогтоол хүлээн авч аймгийн удирдлагуудад танилцуулан, холбогдох хэлтэс, сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Долоо: Сумдын мэдээлэл:

Жаргалант сум: Олон улсын охидын эрхийг хамгаалах өдөр болон Хүүхдийн хүчирхийллийн эсрэг өдрийг тохиолдуулан Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төв, Ховд их сургууль, Хөгжил политехник коллежтэй хамтран “Эерэг хандлагыг хамтдаа бүтээцгээе” уриан дор Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 140 гаруй сурагч, 300 гаруй оюутан залуусыг хамруулсан карнавал жагсаалыг амжилттай зохион байгуулсан ба уг арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, оюутан залуучуудын төлөөлөл 400 гаруй иргэн хамрагдаж, олон нийтэд эерэг хандлагыг төлөвшүүлсэн томоохон үйл явдал болов.

Дэлхийн багш нарын өдөр, Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулагддаг Хотын Захирагчийн нэрэмжит “Багшийн авъяас” наадмыг сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, шатар, олс таталт спортын 5 төрлөөр зохион байгуулж шилдэг баг хамт олныг шалгаруулав.

Сумын Засаг даргын 2017 оны А/217 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хувийн хэвшлийн 14 цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй 10 иргэний үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Жаргалант сумын хүүхдийн нэгдсэн чуулганыг амжилттай зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй болон сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүд болох нийт 250 төлөөлөл хүүхэд хамрагдаж, чуулганаар Засаг даргын орлогч Ц.Лувсанлхамо, Цагдаагийн Олон нийттэй харилцах албаны ажилтан М.Оюунсүрэн нар хүүхдийн элч, төлөөлөгчөөр сонгогдов.

Сумын дүнгээр төмс 932,1тн, хүнсний нарийн ногоо 1374,2тн, үр тариа 14,9тн, тэжээлийн ургамал 11тн-ийг тус тус хураан авч ургац хураалтын дүн мэдээг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Статистикийн хэлтэст хүргүүллээ.

“Цэвэрч Ховдчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 14,1 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл боловсруулан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар шийдвэрлүүлээд байна. Сумын нэмжээнд нохой устгах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж тайлант сард 209 нохой устгаж, устгасан 505 нохойг хог хаягдлын цэгт булшлав.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлж Бүх нийтээр мод тарих өдрөөр Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж байгаа 56 аж ахуйн нэгж, байгууллагын 1507 иргэний оролцоонд тулгуурлан хотын төвийн хайс хашлагийн төгөлд нийт 5029 ширхэг хайлаас, 952 ширхэг улиас, 70 ширхэг голт бор тус тус тариалав.

Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлаар Ерөнхий боловсролын 7 сургуулийн сурагчид, Ховд их сургууль, Хөгжил политехник коллежийн багш, оюутнууд Бичигтийн хөтөл орчмын 12 м³ буюу 4 машин хог түүж хур хогийг хогын цэгт устгав.

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас “Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, төвлөрсөн ус хангамжийн эрүүл ахуйн бүсийн зураглал” хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгийн явцад боловсруулан гаргасан зураг төсөлд 12 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнууд санал бодлоо солилцсоны үр дүнд Буянт голын сав дагуу ойр байрладаг Буянт, Цамбагарав, Рашаант багийн дарга нартай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар болов.

Буянт сум: Тайлант сард иргэдээс бичгээр 3 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэв. Иргэний бүртгэл мэдээллийн үйлчилгээгээр шинээр төрсөн 62, гэрлэлтийн бүртгэл 25, нас баралтын бүртгэл 18, иргэний шинэчилсэн бүртгэлийг 95, анх удаа иргэний үнэмлэх авч байгаа 49, 25 насны сунгалтыг 37, 45 насны сунгалтыг 25, эцэг тогтоолтын бүртгэлийг 10, эд хөрөнгийн анхны бүртгэлээр 60 иргэнд тус тус үйлчлэв.

Сумын Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн ажилчид Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан хамтарсан урлагийн тоглолт зохион байгуулж шилдэгүүдээ шалгаруулав. Тайлант сард номын сангаар давхардсан тоогоор 65 уншигчид 122 ширхэг номоор үйлчлүүлэв. Номын коллектор төвд монголын уран зохиолууд болон, танин мэдэхүй, хүүхдийн зохиол зэрэг 1 сая төгрөгийн захиалга хийж номын фондыг баяжуулав. Бүх нийтээр мод тарих өдрөөр

байгууллагын урд талбайд 30 ширхэг суулгац тарьж, өөрийн орлогод соёл урлагийн үйлчилгээгээр 90.000 төгрөг төвлөрүүлж ажиллав.

Сумын Эрүүл мэндийн төв нь тайлант сард урьдчилан сэргийлэх үзлэг 91, амбулаториор 158, гэрийн идэвхитэй эргэлт 20, идэвхитэй хяналтаар 105 удаа явж нийт 371 иргэнд үйлчилсэн ба 23 өвчтөн хэвтэн эмчлүүлж, алсын дуудлагад 13 удаа явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэж ажиллав.

Жирэмсний хяналтанд шинээр 2 эхийг, эхний 3 сартай нярайг 100% тус тус хяналтанд авч, зохих шинжилгээнд хамруулж байна. Товлолын дагуу дархлаажуулалтанд 21 хүүхэд хамруулсан ба хамрагдалт 99 хувьтай байна.

Сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд хамтран нийт ахмадуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулав.

Томуугийн вакцинд архаг хууч өвчтэй өндөр настан ахмадууд болон жирэмсэн эхчүүдийг бүрэн хамруулав.

Сумын Янзага цэцэрлэгийн багш ажилчид, хүүхдүүдийг цахим бүртгэлд бүртгэж, хүүхдийн ахицын үнэлгээг гарган эцэг эхчүүдэд цэцэрлэгийн сургалтын орчны байдал, бүлгийн эцэг эхийн хэрэгцээ шаардлага, сургалтын орчинг тохижуулахад эцэг эхтэй хамтран ажиллах нь чухал байгааг танилцуулж санал бодлоо солилцов.

Сумын Засаг даргын А/107 дугаар захирамжаар төл малд эрүүл мэндийн үзлэг хийх, вакцинжуулах тарилгад хамруулах ажлын хэсэг томилогдон 5 багийн 49287 төл малд үзлэг тандалт хийж, угаалга тарилга, туулгалтад бүрэн хамруулж, малын хашаа, отог бууцыг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг хийж гүйцэтгэв.

Сумын хэмжээнд 6400 тонн хадлан, 1500 тонн гар тэжээл, 105 тонн хужир шүү бэлтгээд байна.

Сумын хэмжээнд 13 иргэнд холбогдох хуулийн дагуу хууль зүйн зөвлөгөө өгч, хэсгийн төлөөлөгч болон цагдаа нар шөнийн эргүүлийг 15 удаа 135 цаг гарч, ахуйн дуудлагад 3 удаа, биеэ авч явах чадваргүй согтолттой 1 иргэнийг түр саатуулан ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажиллаа. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг хүнсний дэлгүүрүүдэд давхардсан тоогоор 25 удаа хяналт шалгалт хийж ажиллав. Сумын эрх зүйн болон нийгмийн бодлогын ажилтнууд хамтран иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн талаар сургалт зохион байгуулав.

Дарви сум: Ахмадын баярын арга хэмжээг зохион байгуулж, сумын 250 ахмад настнуудад хүндэтгэл үзүүллээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/448 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж байгаа иргэдтэй хийх төлөвлөгөөт бүсчилсэн сургалтыг Дарви суманд зохион байгуулж, Зэрэг, Манхан, Чандмань сумдын алба хаагчид хамрагдав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны санхүүжилтээр хийгдсэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн төв байрны засварын ажил дуусаж үйл ажиллагаа жигдрэв.

Сумын эмнэлэг тайлант сард урьдчилан сэргийлэх үзлэгийг 452, гэрийн идэвхитэй эргэлт 67, диспансерийн үзлэгийг 39, гэрийн дуудлагаар 44 иргэнд эмнэлгийн анхан тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэв.

Томуугийн мэдээг долоо хоног бүр нэгтгэн гаргаж аймгийн Эрүүл мэндийн газарт мэдээлж байна.

Дөргөн сум: Сумын удирдлагын зүгээс Увс аймгийн Завхан сумын төрийн албан хаагчдын төлөөлөл болон удирдлагуудыг урьж салбар салбарын ажилтнуудын харилцан туршлага солилцох нөхөрсөг уулзалт, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, тус арга хэмжээнд 150 гаруй албан хаагчид хамрагдав.

Нутгийн өөрөө удирдах байгууллага үүссэний 25 жилийн ойн арга хэмжээний хүрээнд нутгийн удирдлагын байгууллагад ажиллаж сумын харъяат үе үеийн төлөөллийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай ХХААХҮ-н сайдын 01, аймгийн Засаг даргын 05,06,07 тоот албан даалгаврын хэрэгжилтийн биелэлт, сумын өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг тооцож, холбогдох байгууллагуудад хүргэв.

Сумын хэмжээгээр 1222 тн байгалийн хадлан, 263 тн гар тэжээл, 321 тн хужир шүү, сумын аюулгүйн нөөцөд 50 тн өвс бэлтгээд байна. Сумын төсөвт байгууллагууд 120м³ мод, 680 тн нүүрсний хэрэгцээ байгаагаас түлшний модыг 100хувь, нүүрсний татан авалт 30 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуншлага тааруу, бэлчээр гандуу байгаа учир зэргэлдээ Увс аймгийн Завхан, Наранбулаг, Өлгий сумын удирдлагууд болон малчидтай харилцан тохиролцож зарим нэг малчдыг дээрх сумдын нутгуудаар намаржуулж байна.

Төрийн байгуулагуудын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, 5 албан байгууллага өөрсдийн хийсэн ажлын тайлан мэдээг танилцуулж, бүтээлийн үзэсгэлэн гаргаж, брошур гарын авлага тарааж, иргэдийн санал хүсэлтэд шуурхай хариу өгч, эрүүл мэндийн болон бусад төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж ажиллав. Энэ үйл ажиллагаанд 60 гаруй иргэд оролцож үйлчилгээ авсан.

Малжуулах төсөлд хамрагдсан Агваш, Сээр, Аргалант багийн 11 өрхөд 1232 бог малыг айл өрхөд хүлээлгэн өгөв. Бруцеллёзын вакцинд нийт 1028 бод мал, 42859 бог малыг хамруулж вакцинжуулав.

Авто тээврийн татвар төлөх мэдээллийг татварын өртэй 2 татвар төлөгчид хүргэж, 1 600 000 мянган төгрөгийн татварын өрийг бүрэн барагдууллаа.

Улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлтийн бүртгэлийг 5 иргэнд, нас баралт 1, гэрлэлт 1, шилжиж ирсэн 4, шилжиж явсан 2, иргэний үнэмлэх шинээр захиалсан 23, цахим үнэмлэх дахин захиалсан 13, иргэний бүртгэл, хуулийн этгээдийн 1, эд хөрөнгийн эрхийн 1 иргэний бүртгэлийн баримт бичгийг тус тус хүлээн авч, нийт 51 иргэнд үйлчлэв.

Хүнсний эрхийн бичгийг 21 өрхийн 150 иргэнд олгож, 1.4 сая төгрөгийн хүнсний бараа бүтээгдэхүүн олгов. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны асуулга зөрүүтэй өгсөн 252 өрхийн мэдээллийг залруулж, тайлан мэдээг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлсэн ба 183 ахмад настны судалгааг шинэчлэн, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох 10 иргэнд хувийн хэрэг нээн программд шивж, урьд сард олгогдоогүй 12 иргэний тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн олгов .

Мод тарих үндэсний өдрөөр сумын хэмжээнд 118 суулгац мод тарихаар төлөвлөж, сумын Засаг даргын Тамгын газар 26ш гар хуайс, хүн эмнэлэг 15ш улиас, хүүхдийн цэцэрлэг 40ш улиас, Усан цахилгаан станц улиас 15ш, нохойн хошуу 5, ханд бургас 14, хайлаас 11, таван салаа бургас 5 , Ерөнхий боловсролын сургууль 32ш шар хуайс тариалав.

Газар зохион байгуулалтын чиглэлээр өмчлөлөө салгуулахыг хүссэн 1, эзэмших 1, худалдан авах 1, өвөлжөө хаваржааны 1, гэр бүлийн зориулалтаар эзэмших 1 иргэний өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэлтийн шатандаа байна.

Олон үндэстэн ястны өв соёл хөтөлбөрийн хүрээнд Дөрвөдийн язгуур урлагийг сурталчлах өв соёлын чиглэлээр харилцан туршлага солилцох зорилгоор Увс аймгийн Өлгий, Завхан сумдад “Дөрвөд түмний дуун цацал” нэртэй тоглолтыг зохион байгуулж өөрийн орлогыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Зэрэг сүм: Албан байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлан Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, ард иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай хүргэж үйлчлэв.

Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хэрэгжиж буй албан байгууллагуудыг дулааны шугам сүлжээнд холбох ажил амжилттай хэрэгжиж бүх албан байгууллагуудыг нэгдсэн дулаанд холбон галлагааг эхлүүлээд байна.

Сумын газрын даамал, Багийн Засаг дарга нар хамтран ард иргэдийн өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны бүс газрыг нарийвчлан тогтоож, гэрчилгээжүүлэв.

Сумын Бүжинхэн цэцэрлэг 180 гаруй хүүхэдтэйгээр сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд багш нарын баярын өдрийг тохиолдуулан ажил үйлсээрээ хамт олноо манлайлан ажилласан багш ажилчдаа шагнаж урамшуулан нийт багш ажилчдын дунд сагсан бөмбөг, гар бөмбөг, даамны тэмцээн зохион байгуулж аваргуудаа тодрууллаа. Мөн багш ажилчдын дунд коридор тохижуулах уралдаан, бүтээлчээр оролцож хүүхдийн хөгжих, сонголтын цагаар анги танхимаас гадна коридортоо хүүхдийн байгаль нийгмийн орчны мэдлэг төсөөллийг нэмэгдүүлэх зорилгоор байгалийн буланг тохижуулсан бүтээлч ажлуудыг өрхүүлж ажиллав.

Сумын хүн эмнэлэгт тайлант сард 313 хүн үйлчлүүлсэн ба үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 78, диспансерийн хяналтанд 48, гэрийн идэвхтэй эргэлт 39, амбулторын үзлэг 129, гэрийн дуудлагаар 19, ЭХО үзлэгт 43 иргэн үйлчлүүлж, 21 иргэнийг А13 маягтаар дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэв. Түргэн тусламжийн дуудлага 13 дуудлаганд үйлчилснээс осол гэмтлийн дуудлага гараагүй болно. 0-2 насны 56 хүүхэд, 7 ба 15 насны 117 хүүхдийг сахуу татрангийн дархлаажуулалтанд тус тус хамрууллаа. Мөн ахлах ангийн 110 охид, хөвгүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, “БЗДХалдвар, Бэлгийн эрүүл ахуй” сэдэвт сургалтаар зөвлөгөө өгч ажиллав.

Физик эмчилгээнд 11 хүн, лабораторын шинжилгээнд 316 хүн, цэцэрлэгийн насны 126 хүүхдийн цусны бүлэг тодорхойлж, 112 хүүхдэд цагаан хорхойн шинжилгээ хийснээс 47 хүүхдэд шимэгч хорхойн өндөг илэрч эмчилгээнд хамруулаад байна. Цусны ерөнхий шинжилгээнд 12, сахар 9, хеликобактер 5, элэгний В С вирусын шинжилгээнд 5, мазок 2, ДОХ, тэмбүүгийн шинжилгээнд 2, жирэмсний шинжилгээнд 13, шээсний шинжилгээнд 30 хүн тус тус хамрууллаа.

Манхан сүм: Мерсу corps Олон улсын байгууллага, гамшгаас хамгаалах төслийн баг хамт олон сумын төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, МЭҮ-ийн тасгийн

эмч нарт “Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандарт” 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, сумын гамшгийн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлав.

Сумын удирдлагууд “Иргэдээ сонсоё” аяны хүрээнд сумын ЭМТ-тэй хамтран хөдөө аж ахуйн 5 багийн айл өрхүүдээр явж, малчдын эрэлт хэрэгцээ, тулгамдаж байгаа асуудал болон өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн хангасан байдалтай танилцаж харилцан мэдээлэл солилцов.

Төгрөг гол багийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг сумын төвийн айл өрхүүдээр нэг бүрчлэн орж хог хаягдлын татвар, агаарын бохирдлын судалгаа, газар олголтын талаарх мэдээлэл түгээж гудамж талбайд муу ус асгахгүй байх, ойр орчноо цэвэр цэмцгэр байлгах чиглэл өгч иргэдийн санал хүсэлтийг сонсов.

Бөхөн клубын багш, сурагчид “Цоохор ирвэсийн эх нутаг-2017” баруун бүсийн наадамд амжилттай оролцож багт наадам үзүүлбэрээр 1 дүгээр байр эзэлж амжилттай оролцов.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Бидний авьяас-2017” урлагийн бага наадмыг сумын Соёлын төвтэй хамтран бага, дунд, ахлах гэсэн 3 насны ангиллаар зохион явуулж төрөл тус бүрд эхний 3 байрыг шалгаруулж, тэргүүний багийг шагнаж урамшууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв 26 оро тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж тайлант сард урьдчилан сэргийлэх үзлэгт 218 хүн хамруулсан ба эмнэлэгт 42 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна.

Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 34 хүүхэд хамрагдаж, 4 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 11 дуудлаганд үйлчилэв. 0-5 насны хүүхдийг сар бүр жигнэж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллахын зэрэгцээ хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд стандартын дагуу 210 нэр төрлийн эмээр үйлчилж 90 хувийг тендэрээс авч хэрэглэж байна.

“Элэг бүтэн-Монгол” хөтөлбөрийн хүрээнд хөдөө багуудын зорилтот бүлгийн өрхүүдээр явж хамрагдалтыг нэмэгдүүлж, хамрагдалт 51 хувьтай байна.

МЭҮН-үүд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд ДХХ-32332, дуут хавдар-1563, цусан халдвар-4277, коли иж балнад-4425, шөвөг яр-35400, сохор догол-33630, томуу-1298, сахуу-2715, галзуу-4602, Бруцеллёз-101200, штамп 19-1597, боом-413 нийт 223452 малд аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хийж тайлан мэдээг хугацаанд холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргэв.

Сумын хэмжээнд нийт 220.58 га-д тариалалт хийсэн ба төмс хүнсний ногоо 170.09 тонн, тэжээлийн ургамал 291 тонн, үр тариа 7 тонныг хураан авч ургац хураалтын мэдээг дээд шатны байгууллагад хүргэв.

Мөст сүм: Сумын удирдлагууд Ахмадын баярын өдрөөр ахмадуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ ахмад настны талаар төрөөс баримталж буй бодлого, ахмад настанд чиглэсэн хууль, хөтөлбөрийн талаар тэдэнд мэдээлэл өгч, урлаг, спортын арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Намрын ээлжит цэрэг татлагад цэргийн насны 22 залуучууд хамрагдаж 8 залуу цэргийн албан тэнцэж, Говь-алтай аймгийн Алтай суманд байрладаг хилийн цэргийн ангид хугацаат цэргийн алба хаах болов.

Малчин залуучуудын чуулга уулзалт урлаг, спортын бага наадмыг 10 сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэ үйл ажиллагаа нь малчин залуучуудын нийгмийн оролцоог өрнүүлэх, тэдэнд төр засгийн бодлого шийдвэрийг танилцуулах, авьяас чадварыг нээн илрүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой арга хэмжээ болов.

Сумын удирдлагууд сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцаж бүтээгдэхүүний чанар, орц норм, эрүүл ахуй стандартад хяналт тавьж үүрэг чиглэл өгөв.

Сумын төсөвт байгууллагууд “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, тус өдрийн хүрээнд төрийн алба, үйлчлэгээний чанар хүртээмжийн талаар иргэдийн санал авах хайрцгийг ажиллуулж иргэдээс гарсан саналыг хүсэлтийг хүлээн авч, зохих төрийн үйлчилгээг үзүүлэв.

Нийгмийн халамжийн сангаас 42 иргэнд 140 000 төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмжийг 12 хүүхдэд, ахмад настны асаргаанд 57 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асаргаанд 15 хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаанд 10 хүүхэд, бүтэн өнчин буюу асрамжинд байгаа 3 хүүхэд, 16-аас дээш насны иргэдийн эм тарианы үнэ хөгжлийн бэрхшээлтэй иргэн 7 хүнд, ахмад настан 17 хүнд, 16-аас доош насны эм тарианы үнэ 10 хүүхдэд сар бүр 140 000 мянган төгрөг тус тус олгож байна.

Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан байнга оршин суудаг ахмад настан аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд эмчлүүлж шинжилгээ хийлгэсэн 5 иргэнд унааны нэг талын зардал 295 000 төгрөгийн хөнгөлөлтийг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн хуулийн дагуу олгож

шийдвэрлэв. Ахмад настны шүдний хөнгөлөлтөнд 2 ахмадыг хамруулж, 240 000 төгрөгийн хөнгөлөлт олгов. Асаргаанд орох хүсэлтэй 2 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч, амьжиргааг дэмжих зөвлөлөөр 1 иргэний өргөдлийг хуулийн хүрээнд шийдвэрлэв.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигын дагуу бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр 80ш модыг хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнд тариалав.

Монголын болон дэлхийн багш нарын баярыг өдрийг тохиолдуулан багш нарын баярыг тэмдэглэн, сургуулийн шилдэг 9 номинаци, тэргүүний анги хамт олон болон тэргүүний сурагчдыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Сумын Эрүүл мэндийн төв нь нийт 515 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 358, гэрийн идэвхтэй хяналтын үйлчилгээг 114 иргэнд, дуудлагаар 43 иргэнийг үзэж, жирэмсний хяналтанд шинээр 3 иргэнийг авч, 22 иргэн хэвтэн эмчлүүлсэн.

Чандмань сум: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар байгаль цаг агаарын хүндрэлтэй байдлын улмаас сумын малчид өөр аймаг сумдын бүс нутагт олноор шилжин суурьших болсонтой холбогдуулан сумдын удирдлагуудын хооронд байгуулах санамж бичгийн загвар, тухайн сумдын багийн Засаг дарга нартай малчид гэрээ байгуулж хамтран ажиллах гэрээний загвар зэргийг хэлэлцэн баталж тогтоол гаргав.

Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойн арга хэмжээний үеэр нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультан, ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгуулж тус үйл ажиллагаанд сумын удирдлагууд, үе үеийн сонгуультан, ажилтан албан хаагчид 60 гаруй хүн оролцов. Ойн үеэр орон нутгийн зам дагуух 12 саданд гоёлын харгана, шар хуас тарих бүтээлч ажлыг хийж, спорт, урлагийн тэмцээн зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар нь жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Ахмадын баяр, Мод тарих үндэсний өдөр, Бүх нийтийн цэвэрлэгээ, өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл, бог, бод малын вакцинжуулалт зэрэг цаг үеийн ажлуудад төсөвт байгууллагуудтайгаа хамтран идэвхи санаачлагатай ажиллаж, сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, эх орон байгаль дэлхийгээ хайрладаг уламжлалт монгол зан заншлаа дээдэлж ногоон орчинг бүрдүүлэх эрхэм үйлсэд ард иргэдийг уриалан мод тарих, бүх нийтийн цэвэрлэгээнд айл өрх, иргэн бүрийг идэвхтэй хамруулав.

Өвөл цагийн хүмүүжлийн ажил, мэдээлэл түгээх ажил өрнүүлэн сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого, хууль эрхзүйн ажилтан, Байгаль орчны улсын байцаагч, Хэсгийн төлөөлөгч нар хамтран төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн төлөөлөл 120 гаруй иргэдэд Зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулж, иргэдэд нэн шаардлагатай заалтуудаар гарын авлага, тараах материалуудыг хийж тараав. \

Тайлант сард Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд шинээр төрсөн хүүхэд 1, гэрлэлт 1, нас баралт 2, 25, 45 насны иргэдийн паспортын сунгалт 1 тус тус иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэж ажиллав.

Мал эмнэлэг үржлийн тасаг нь төл малд бог малын мялзан төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг хангах үүднээс аймгийн МЭҮТ–аас чиглэл болгосон хуваарийн дагуу тээвэрлэлтээр 99500 тун вакциныг татан авалтаар хүлээн авсан.

Аймгийн Засаг даргын 2017 оны А\438 дугаар захирамж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган сумын Засаг даргын 2017 оны А\61 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан МЭҮН–үүдэд вакцины хуваарилалтыг горимын дагуу хийж, 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр 10 дугаар сарын 05–23-ны өдөр хүртэлх 13 хоногийн хугацаанд 2140 км замыг туулж, 360 гаруй летр шатахуун зарцуулан 84293 мянган төл малыг вакцинжуулж, ажлын гүйцэтгэл 4,7 хувийн биелэлтэй байна. Үүнийг МЭҮН–ээр авч үзвэл: “Бумбатын сүрэг МЭҮН” 34100 мянган төлд тарихаас 30527 мянган төлд тарилга хийж 89,5%-ийн гүйцэтгэлтэй “Хотонт нуур МЭҮН” 29300 мянган төл малд тарилга хийхээс 20624 мянган төлд хийж 70,3%-тай “Зах таван булаг МЭҮН” 36000 мянган төлд тарилга хийхээс 33142 төлд хийж 92,0 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд Амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж, нийт 704 иргэнд 171914.0 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжид нийт 66 иргэнд 25344.0 мянган төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 118 иргэнд 27100.0 мянган төгрөг, Ахмад настны унааны зардалд 18 иргэнд 2730.0 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний харилцаа холбооны зардал 3 иргэнд 160.0 төгрөгийн тэтгэмжийг олгож халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж үйлчлэв.

Сумын эрүүл мэндийн төв нь тайлант сард 381 иргэнд амбулаториор үйлчилж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Ахмадын баяраар нийт 80 ахмад настанд “Хорт хавдар түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулсны дээр хөзөрийн тэмцээнийг зохион байгуулж шилдэг баг тамирчдыг шалгаруулж шагнаж урамшуулав.

Хүүхдийн цэцэрлэгийн 12 багш ажилчид, Ерөнхий боловсролын сургуулийн 22 багш, ажилчдыг хамруулан артерийн гипертензи, чихрийн шижингийн илрүүлгийн үзлэгийг биохимийн оношлуураар хийж хөхний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт тус тус хамруулан ажиллаа. Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны А\28 тоот тушаалын дагуу дархлаажуулалтын 10 хоногоор 2-т вакцинд 8 настай 42 хүүхдийг, 15 настай 18 хүүхдийг, томуугийн эсрэг вакцинд өндөр настан 65, жирэмсэн 20 эхийг тус тус хамруулав.

Дэлхийн багш нарын болон Монголын багш нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд багш нарын дунд 8 номинацад шалгаруулан ажлын үр дүнгээр нь шилдэг багш ажилчдыг шагнаж урамшуулав. Шилдэг 8 багшийн ажлын туршлага, шилдэг хичээлийн саналуудыг сурталчлан бүтээлийн үзэсгэлэн гаргаж олон нийтэд түгээв. Сургуулийн нийт багш ажилчдын сурган хүмүүжүүлэх хурлаар сургуулийн үйл ажиллагааны тайлан, 2017-2022 оны хөгжлийн төлөвлөгөө, 2017-2018 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, дотоод журамд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг хэлэлцэн баталлаа.

“Урлагийн наадам-2017” тэмцээнийг бага ангийн сурагчдын дунд зохион байгуулж 1, 2, 3 дугаар байр эзэлсэн сурагчдыг шагнаж урамшуулснаар багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг дэмжсэн үр дүнтэй ажил болов.

Сумын Соёлын төв, Ерөнхий боловсролын сургуулийн номын сангаас “Номын гэгээ” хөтөлбөрийн хүрээнд уншигчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, яруу найргийг дэлгэрүүлэх, Монголын шинэ үеийн утга зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн уран бүтээлийг уншигчдад сурталчилах, сурагчдын сэтгэлгээг идэвхижүүлэх, эх хэлний зөв хэрэглээг хэвшүүлэх, тэдний хэл яриаг зүгшрүүлэх үүднээс “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж, шинэ номын үзэсгэлэн гаргаж цаашид хийгдэх номын баяжилт, хамтран ажиллах талаар санал асуулга авч АХА тэмцээнийг зохион байгуулсан ба уг арга хэмжээнд 1-12 ангийн нийт 250 гаруй сурагч хүүхдүүд номын хорхойтнууд хамрагдав.

Сумын хүүхдийн цэцэрлэг багш ажилчдын нэгдсэн хурлыг хийж заах аргын нэгдлээс тухайн сард зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн баталж, нийт цэцэрлэгийн 56 эцэг эхэд “Хүүхэд хамгаалал дасан зохицол” сэдвээр сургалт хийж эцэг эхийн санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.

Багш ажилчид, эцэг, эхчүүд, хүүхдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Алтан намар” нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, багш ажилчид, хүүхдүүдийн “Бүтээцгээ” бүтээлийн үзэсгэлэн, Эцэг эхчүүд “Миний хүүхдийн дуртай зоог” хоолны үзэсгэлэн гаргаж нийт эцэг, эхчүүдийн 80 гаруй хувийг хамруулан эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэн ажиллаа.

Сумын соёлын төв тайлант сард хийсэн ажил, цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө танилцуулан шинэ номын үзэсгэлэн гаргаж, музейн үзмэрүүдийг олон нийтэд сурталчилан танилцуулав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР